# БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Булган аймгийн Дашинчилэн сумын цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2025/043/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Булган аймаг<br><br>2025 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал:Д.Мягмарсүрэн<br>Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.et@gmail.com<br><br>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн<br>Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ............................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....................................................................................
    3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ................................................................................
    3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ...............................................................................
    3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....................................................................
    3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ..........
4. Аудитын тайлан.........................................................................................................
    4.1 Ерөнхий зүйл ..........................................................................................
    4.2 Материаллаг байдал .........................................................................
    4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.......................................................
    4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........
    4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
    .....................................
    4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......................................................................
5. Аудитын илрүүлэлт .............................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....................................................


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 218

танай ________ ны № ________ т

БУЛГАН АЙМГИЙН ДАШИНЧИЛЭН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Н.АЛИМАА ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Дашинчилэн сумын цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашинчилэн сумын цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Дашинчилэн сумын цэцэрлэг нь 2024 онд 175 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж үүнээс 100 хүүхэд үндсэн цэцэрлэгт, 75 хүүхэд хувилбарт хөтөлбөрт хамрагдаж гүйцэтгэлээр санхүүжсэн. Тайлант онд Боловсролын яамнаас 27.099.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, орон нутгийн хөрөнгө оруулалтаас 19,808.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авч санхүүгийн тайланд тусгасан байна.

### Аудитын гол асуудал

Боловсролын байгууллага гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжүүлэх болсноор сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ 7 болж зардлын зүйл анги багасаж, ихэнх зардал бараа үйлчилгээний

632502409

бусад зардлаас зарцуулах болсон байна.

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 128 тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон байна. Мөн 2024 оны 9 сарын 1-нээс Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 сарын 26-ны өдрийн А/85, А/34 тоот тушаалаар "Орон тооны хязгаарын жишиг норматив" батлагдсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр нийт 5 зорилтын хүрээнд арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллан 92.5 хувьтай дүгнүүлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЭНХЦООДОЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **171,540,559.01** | **227,897,372.28** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 116,603,409.01 | 169,286,622.28 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 116,603,409.01 | 169,286,622.28 |
| **3121** | **Төгрөг** | 116,603,409.01 | 169,286,622.28 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 116,603,409.01 | 169,286,622.28 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 54,937,150.00 | 58,610,750.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 180,000.00 | 180,000.00 |
| 35130 | Эм боох материал | 180,000.00 | 180,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 54,757,150.00 | 58,430,750.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,548,700.00 | 2,517,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 44,563,350.00 | 49,180,300.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,342,600.00 | 4,430,050.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,302,500.00 | 2,302,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **628,470,362.09** | **662,257,301.65** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 628,470,362.09 | 662,257,301.65 |
| **392** | **Биет хөрөнгө** | 617,865,112.12 | 651,820,801.68 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 904,442,293.38 | 904,442,293.38 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (355,302,983.53) | (363,051,763.63) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 32,586,040.00 | 59,266,530.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (15,127,838.17) | (18,449,835.46) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 39,461,331.50 | 63,817,175.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (19,467,171.08) | (22,152,178.15) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 33,017,600.00 | 33,017,600.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (1,744,159.98) | (5,069,019.96) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 10,605,249.97 | 10,436,499.97 |
| 39301 | Програм хангамж | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (588,750.03) | (757,500.03) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,844,000.00 | 9,844,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **800,010,921.10** | **890,154,673.93** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **705,154,067.75** | **890,154,673.93** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 705,154,067.75 | 890,154,673.93 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 9,844,000.00 | 104,700,853.35 |
| 51101 | Өмч:  - төрийн | 9,844,000.00 | 104,700,853.35 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 487,990,758.63 | 578,134,511.46 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 487,990,758.63 | 487,990,758.63 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 90,143,752.83 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 207,319,309.12 | 207,319,309.12 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **705,154,067.75** | **890,154,673.93** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **825,421,312.00** | **759,261,684.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **314,892,512.00** | **58,652,584.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 314,892,512.00 | 58,652,584.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 314,892,512.00 | 58,652,584.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 313,892,512.00 | 58,652,584.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **510,528,800.00** | **700,609,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 477,648,800.00 | 668,729,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 477,648,800.00 | 668,729,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,880,000.00 | 31,880,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,880,000.00 | 31,880,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **460,651,755.79** | **664,247,931.17** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **460,651,755.79** | **664,247,931.17** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 457,899,288.49 | 664,110,222.51 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 277,036,818.52 | 453,920,273.00 |
| 210101 | Үндсэн цалин | 266,775,934.82 | 297,869,670.00 |
| 210102 | Нэмэгдэл | 7,425,737.70 | 131,908,078.00 |
| 210104 | Урамшуулал | 2,835,146.00 | 24,142,525.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,400,051.25 | 62,741,893.73 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,566,889.69 | 43,335,383.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 475,398.04 | 4,853,663.96 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 362,718.42 | 2,804,557.64 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 88,247.62 | 2,313,452.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 906,797.48 | 9,434,836.61 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,127,532.70 | 29,942,291.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,805,532.70 | 19,221,473.34 |
| 210302 | Түлш, халаалт | 22,752,000.00 | 10,540,818.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 570,000.00 | 180,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 772,500.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 772,500.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 63,275,830.00 | 67,523,570.00 |
| 210502 | Хоол, хүнс | 63,275,830.00 | 67,523,570.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 259,600.00 | 891,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 259,600.00 | 891,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 34,026,956.02 | 49,090,594.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,576,662.00 | 18,578,850.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,443,300.00 | 13,262,350.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 13,006,994.02 | 17,249,394.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,752,467.30 | 137,708.66 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,752,467.30 | 137,708.66 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,752,467.30 | 137,708.66 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **364,769,556.21** | **95,013,752.83** |
| 225 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 6,990,100.00 | 4,870,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 6,990,100.00 | 4,870,000.00 |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (6,990,100.00) | (4,870,000.00) |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **357,779,456.21** | **90,143,752.83** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **511,528,800.00** | **700,609,100.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,000,000.00** | **-** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 1,000,000.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,000,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | - |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **510,528,800.00** | **700,609,100.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 477,648,800.00 | 668,729,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 477,648,800.00 | 668,729,100.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,880,000.00 | 31,880,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,880,000.00 | 31,880,000.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **445,103,481.77** | **647,925,886.73** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **445,103,481.77** | **647,925,886.73** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **442,351,014.47** | **647,788,178.07** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 289,467,857.11 | 458,552,390.00 |
| 210101 | Үндсэн цалин | 211,979,817.83 | 297,869,670.00 |
| 210102 | Нэмэгдэл | 59,235,895.28 | 131,908,078.00 |
| 210104 | Урамшуулал | 18,252,144.00 | 28,774,642.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,308,624.66 | 58,109,776.73 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,366,959.87 | 40,157,483.19 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,741,648.99 | 4,496,532.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,166,839.17 | 2,594,709.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 530,682.31 | 2,142,688.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,502,494.32 | 8,718,362.38 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,127,532.70 | 29,942,291.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,805,532.70 | 7,759,019.34 |
| 210302 | Түлш, халаалт | 22,752,000.00 | 22,003,272.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 570,000.00 | 180,000.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 63,998,000.00 | 65,611,020.00 |
| 210502 | Хоол, хүнс | 63,998,000.00 | 65,611,020.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 1,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,800,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 852,800.00 | 2,224,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 852,800.00 | 2,224,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,596,200.00 | 31,548,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,237,300.00 | 25,060,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,358,900.00 | 6,488,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,752,467.30** | **137,708.66** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,752,467.30 | 137,708.66 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,752,467.30 | 137,708.66 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **66,425,318.23** | **52,683,213.27** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 66,425,318.23 | 52,683,213.27 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 116,603,409.01 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 116,603,409.01 | 169,286,622.28 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **104,700,853.35** | **207,319,309.12** | **487,990,758.63** | 800,010,921.10 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **104,700,853.35** | **207,319,309.12** | **487,990,758.63** | 800,010,921.10 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **104,700,853.35** | **207,319,309.12** | **487,990,758.63** | 800,010,921.10 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 90,143,752.83 | 90,143,752.83 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **104,700,853.35** | **207,319,309.12** | **578,134,511.46** | 890,154,673.93 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 810,408,800.00 | 647,788,178.07 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 810,408,800.00 | 647,788,178.07 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 810,408,800.00 | 647,788,178.07 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 601,197,300.00 | 458,552,390.00 |
| 210101 | Үндсэн цалин | 421,088,700.00 | 297,869,670.00 |
| 210102 | Нэмэгдэл | 172,617,700.00 | 131,908,078.00 |
| 210104 | Урамшуулал | 7,490,900.00 | 28,774,642.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 69,474,600.00 | 58,109,776.73 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,244,300.00 | 40,157,483.19 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,556,500.00 | 4,496,532.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,778,900.00 | 2,594,709.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,778,900.00 | 2,142,688.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,116,000.00 | 8,718,362.38 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,080,000.00 | 29,942,291.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,500,000.00 | 7,759,019.34 |
| 210302 | Түлш, халаалт | 22,400,000.00 | 22,003,272.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 180,000.00 | 180,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 71,768,100.00 | 65,611,020.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 71,768,100.00 | 65,611,020.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,224,600.00 | 2,224,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,224,600.00 | 2,224,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33,864,200.00 | 31,548,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,375,800.00 | 25,060,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,488,400.00 | 6,488,400.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **116,603,409.01** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **169,286,622.28** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 65,893.6 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 145.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 59,030.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 6,717.3 мянган төгрөгийн 8 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн асуудлаас 7,241.0 мянган төгрөгийн тайлангаар илэрсэн зөрчлүүд нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба тоо хэмжээ их ч санхүүгийн тайланд нөлөөлөх магадлалгүй тул материаллаг багатай гэж үзсэн тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

### 3.1 Төлбөрийн акт

- *Илрүүлэлт:* Хүүхдийн ирцийг тодорхой хоногоор тулган шалгахад багшийн журналын ирцээс, хоолны өдөрлөгөөр ирц зөрүүтэй илүү дутуу бүртгэгдэж 81.0 мянган төгрөгийн хүнсний материал илүү зарцуулагдсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 5.1.5.хариуцлагатай байх, 41.2.7. хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах. гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
- *Илрүүлэлт*: Шатахууны тооцооллыг шалгахад норм нормативыг илүү тооцож 64.7 мянган төгрөгийн шатахуун илүү бодож олгосон байна .Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, ЗТХС-ын 2019 оны 390 тушаалаал батлагдсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг баримталж ажиллаагүй байна.

### 3.2 Албан шаардлага

- *Илрүүлэлт*: Ажил хавсран гүйцэтгэсэн О.Ганхуягийн цалинг бодохдоо хавсран ажиллаж буй албан тушаалын цалингаар бус өөрийн үндсэн ажлын

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

цалингаар тооцон 378.0 мянган төгрөг илүү тооцож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56.1.Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно. 56.2."Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

- *Илрүүлэлт*: Үнэ төлбөргүй хүлээн авсан 46,908.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 11,744.2 мянган төгрөгийн бараа материалын орлогод авсан тушаал болон тооллого томиссын тушаал, эмчийн үзлэгт хамрагдсан үзлэгийн тушаалыг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Цалингийн данстай холбоотой.**

*Илрүүлэлт*: Групптэй ажилтны амралтын бодохдоо групптэй хүнд нэмж олгох 5 хоногийг нэмж тооцоогүй 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**2. Бараа материалын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт*: Эцэг эх, асран хамгаалагчаас авч хэрэглэдэг сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг бүртгэлд тусгахдаа багшийн хүлээн авсан дэвтрээс 1.485.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 1/4511 тушаалын хавсралтын улирал бүр тайлагнах гэсэн заалтуудын хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**3. Зардлын данстай холбоотой.**

*Илрүүлэлт*: Тайлангийн хугацаанд 440.0 мянган төгрөгийн Багш, ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан боловч өгөх ёстой үзлэг шинжилгээнд хамрагдаагүй эхо, үзлэгт хамруулсан байна. Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны А/232 А340 тушаалаар батлагдсан "Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 тушаалаар батлагдсан " Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношлогоонд хамруулах заавар " зэрэг тушаалуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**4. Зардлын данстай холбоотой.**

*Илрүүлэлт*: Нүүдлийн гэр хөтөлбөр арга хэмжээний зардлаас 3.459.8 мянган төгрөгийг СӨБ-ын зардалд шилжүүлэн зарцуулсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 22.6.7.төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах, Му-ын Сангийн сайдын 2023 оны 211-р тушаалыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

5. **Бараа материалын данстай холбоотой.**

*Илрүүлэлт*: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоолны нормыг энгийн хүүхдийн нормоор тооцон 86.9 мянган төгрөг дутуу тооцсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, Засгийн газрын 2024 оны "Хоолны зардлын норматив батлах тухай" 237 дугаар тогтоол-ыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

6. **Зардлын данстай холбоотой.**

*Илрүүлэлт*: Багшийн хөгжлийг дэмжих цахим хэрэглээний зардал болох үүрэн телефоны дата багцыг сонгон хэрэглэхдээ журамд заагаагүй албан хаагчид 144.0 мянган төгрөгийн датаг ашиглуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1-д "энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд “гар утасны зардал"-ыг санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно” гэсэн заалт, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ын 2.4-д "дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний нийт зардлыг нийт үндсэн багш (бүлгийн болон хөгжим, биеийн тамирын багшийн нийт тоо) тоонд хувааж тухайн хугацаанд ашиглах цахим хэрэглээний зардлын нэгжийг тооцно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | АТ тоо | Тоо | Дүн |
| Хүүхдийн ирц илүү бүртгэсэн. | 1 | 81.0 | 1 | 81.0 | | | | | | | | |
| Шатахууны норм буруу тооцож олгосон | 1 | 64.7 | 1 | 64.7 | | | | | | | | |
| Ажил хавсран гүйцэтгэсэн ажилтны цалинг буруу тооцож олгосон | 1 | 378.0 | | | 1 | 378.0 | | | | | | |
| Групптэй ажилтны амралтын нэмэлт 5 хоног бодож олгоогүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Тендерийн материал шаардлага хангаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Үнэ төлбөргүй орлого дутуу бүртгэсэн | 1 | 1,485.5 | | | | | 1 | 1,485.5 | | | | |
| Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгээр хамаарахгүй шинжилгээ өгсөн | 1 | 440.0 | | | | | 1 | 440.0 | | | | |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоолны нормыг дутуу тооцож олгосон | 1 | 86.9 | | | | | 1 | 86.9 | | | | |
| Багшийн хөгжлийг дэмжих дата багцыг журамд заагаагүй албан хаагчдад хэрэглүүлсэн. | 1 | 144.0 | | | | | 1 | 144.0 | | | | |
| Зардал хооронд гүйлгэн зарцуулсан | 1 | 3,459.9 | | | | | 1 | 3,459.9 | | | | |
| **Дүн** | **10** | **6,140.0** | **2** | **145.7** | **1** | **378.0** | **8** | **5,616.3** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан 46,908.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 11,744.2 мянган төгрөгийн бараа материалын орлогод авсан тушаал болон тооллого томиссын тушаал, эмчийн үзлэгт хамрагдсан үзлэгийн тушаалыг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна. | 1 | 58,652.6 | | | 1 | 58,652.6 | | |
| Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цалингийн зардалаас шагнал урамшуулал олгосон. | 1 | 1,101.0 | | | | | 1 | 1,101.0 |
| **Нийт дүн** | **2** | **59,753.6** | | | **1** | **58,652.6** | **1** | **1,101.0** |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **A** | **1** | **2** | **3** | **4** | **5** | **7** | **8** | **9** | **10** |
| 1 | ТШЗ | **1** | **1** | | | **1** | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |